3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Ханх сумын засаг даргын тамгын газрын даргын 2022 оны А/15 тоот тушаалаар дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна.

Тайлант хугацаанд дотоод хяналт хариуцсан нэгж 2022 онд дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хяналт шалгалт хийж, биелэлтийг гарган ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн тул, бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тулгараад байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

Гэхдээ санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхдээ Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. Тухайлбал: Санхүүгийн тайлангийн толилуулгыг бэлтгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайлбар тодруулга хийгээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 357.0 сая төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	34.0	26.1	(7.9)
Бараа материал	82.3	80.0	(2.3)
Үндсэн хөрөнгө	986.6	1,340.5	353.9
Биет бус хөрөнгө	7.2	6.7	(0.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,110.1</b>	<b>1,453.3</b>	<b>343.1</b>
Дансны өглөг	-	0.7	0.7
<b>Эздийн өмч</b>	<b>759.0</b>	<b>759.0</b>	<b>-</b>
- төрийн	759.0	759.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	369.8	369.8	-
Хуримтлагдсан үр дүн	(18.7)	323.7	342.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,110.1</b>	<b>1,453.3</b>	<b>343.1</b>

Нийгмийн даатгалын хэлтсээс 0.2 сая төгрөгийн авлагатай байгаа ба харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулсан байна. 21.0 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах малжуулахын малын авлагын үлдэгдэл, 3.8 сая төгрөгийн авлага нь Өмнөх Засаг даргын тамгын газрын даргын ажлаас халагдаж, Засаг даргаас авах авлага, 0.09 сая төгрөгийн авлага нь хувь хүнд илүү лист олгосон авлага, Цагаан үүр сумын нарс шинэхэн төгөл ой ангиас 1.0 сая төгрөгийн авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.3 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 353.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 297.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.
- Сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 183.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.
- Төсвийн хөрөнгөөр тайлант онд 3.8 сая төгрөгийн техник хэрэгсэл худалдан авсан байна.  
Дансны өглөг 0.07 сая төгрөг бичиг хэргийн материалын өглөг үүссэн байна.

Хуримтлагдсан үр дүн данс 356.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 399.6 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 1.7 сая төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 397.9 сая төгрөгөөр баталсан байна. Ханх сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 06-ны 02 дугаар тогтоолоор тус байгууллагын төсвийг 5.8 сая төгрөгөөр нэмэх тодотгол хийж 403.7 сая төгрөг болгож тодотгон баталсан байна. Тус газрын 2022

оны төсвийг 2021 оны төлөвлөгөө гүйцэтгэлтэй харьцуулбал дараах байдалтай байна.  
**Үүнд:**

Үзүүлэлт	2022 оны батлагдсан төсөв	2021 оны		Төлөвлөгөөтэй харьцуулсан дүн	Гүйцэтгэлтэй харьцуулсан дүн
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	403.7	423.4	416.4	19.7	12.7

**Хүснэгтээс харахад:** 2022 оны төсвийг батлахдаа 2021 оны төлөвлөгөөнөөс 19.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлээс 12.7 сая төгрөгөөр хасаж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 403.7 сая төгрөгийн төсөв баталсан. Орон нутгийн төсвөөс 61.8 хувь буюу 249.8 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгээс 38.2 хувь буюу 153.9 сая төгрөг төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 403.7 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч, 387.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 16.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7<sup>1</sup> дахь заалттай нийцэж байна.

#### Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/сая төгрөгөөр/					
<b>70106</b>	<b>Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>390.1</b>	<b>382.0</b>	<b>8.2</b>	<b>97.9</b>
80101	Үнсэн үйл ажиллагаа	269.7	261.5	8.2	97.0
80106	Баг хорооны үйл ажиллагаа	45.3	45.3	0.0	100.0
80112	Нийтлэг үйлчилгээ	34.3	34.3	-	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	0.5	0.5	-	100.0
80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн тэтгэмж	17.3	17.3	0.0	100.0
81102	Нийтлэг үйлчилгээ	15.0	15.0	-	100.0
82801	Улсын их баяр наадам	8.0	8.0	-	100.0
<b>71413</b>	<b>Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ</b>	<b>13.6</b>	<b>5.6</b>	<b>8.0</b>	<b>-</b>
81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	13.6	5.6	8.0	41.2
<b>НИЙТ</b>		<b>403.7</b>	<b>387.6</b>	<b>16.2</b>	<b>96.0</b>

<sup>1</sup> Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 387.6 сая төгрөг буюу 96.0 хувьтай байна. Тайлант оны төсвийн үлдэгдэл 16.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн ба энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7<sup>2</sup> дахь заалттай нийцэж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан нэмэлт орлого 2.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.6 сая төгрөгийг нэмэлт дансанд орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах орлогууд орсон байна. Үүнд:

- Тендерийн орлого 0.6 сая төгрөг
- Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 2.1 сая төгрөг
- Аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардалд 0.3 сая төгрөгийн орлого орсон байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 0.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжид 1.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулж 0.5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Ханх сумын Засаг даргын тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд хэрэгжилт хангалтгүй байгаа тул зөрчлийг таслан зогсоох, хариуцлага тооцуулах тухай 1 албан шаардлага, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж аудитын байгууллагад ирүүлж байх тухай 1 зөвлөмж, Үндсэн хөрөнгө, бараа материалын данс бүртгэлд бүртгэхтэй холбоотой 90.6 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

<sup>2</sup> Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 420.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгаж байна.

Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 онд байршуулсан мэдээллийг түүвэрлэн хянаж үзэхэд:

1. Тайланд онд цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 20 удаагийн 320.3 сая төгрөг, зарлагын 6 удаагийн 39.2 сая төгрөгийн, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг мэдээлэх талбарт 8 удаагийн 72.7 сая төгрөг, 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллээс 4 удаагийн 58.6 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 0.0 хувьтай байна. Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Ханх сумын засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Цагаан-үүр сумын "Нарс шинэсэн төгөл" сум дундын ойн ангид тусламж болгон олгосон 2.0 сая төгрөгт төлбөрийн 1 акт бүрэн хэрэгжсэн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 албан шаардлага хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Харин өмнөх оны дансны авлагуудыг шүүхийн байгууллагад шилжүүлэн ажилласан байна. Мөн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт албан шаардлагыг биелүүлэн ажилласан байна, Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас уралдаан тэмцээний зардалд 0.7 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 он 43 дугаар тогтоолоор "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээ" - ний талаар өгсөн чиглэлийн 1.6-д заасантай нийцэхгүй байна, Ханх сумын Засаг даргын тамгын газрын улсын бүртгэлийн гэрчилгээ дэх дүрмийн сангийн хэмжээ 36,265 төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 759,000,860.17 төгрөг байгаа ба 758,964,595.17 төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дах заалттай нийцэхгүй байгаад өгсөн зөвлөмжүүдийг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна.

Өмнөх акт албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт 80%-ийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	759.7	3	759.7	100.0
Акт	1	2.0	1	2.0	100.0
Албан шаардлага	1	998.3	0	0	0
Нийт дүн	5	1,760.0	4	761.7	80

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Дараагийн аудитаар давтан шалгах онцгой асуудал байхгүй байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 98.4 сая төгрөгийн залруулгыг аудитын хугацаанд хийж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах албан шаардлага хүргүүлсэн ба албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэн, төсвийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй асуудалд зөвлөмж хүргүүлээ.

##### 5.1 Залруулсан алдаа

Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар орлого, үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, зарцуулсан бараа материалыг үлдэгдэлтэй тайлагнасан нийт 98.4 сая төгрөгийн залруулгыг аудитын хугацаанд хийсэн болно.

##### 5.2 Төлбөрийн акт

Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Ханх сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд цалингий зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 20 удаагийн 320.3 сая төгрөг, зарлагын 6 удаагийн 39.2 сая төгрөгийн, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг мэдээлэх талбарт 8 удаагийн 72.7 сая төгрөг, 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллээс 4 удаагийн 58.6 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ. Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах албан шаардлага хүргүүлсэн ба албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн болно.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийн талаар:

##### Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхдээ Төсвийн тухай хуулийн 54.4, 54.5-т заасан бүрэлдэхүүнийг хангаж ирүүлээгүй байна. Энэ эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал: Санхүүгийн тайлангийн толилуулгыг бэлтгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайлбар тодруулга хийгээгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж, аудитын байгууллагад ирүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Данс бүртгэлд бүртгээгүй	4	98.4	4	98.4			4	98.4				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>98.4</b>	<b>4</b>	<b>98.4</b>			<b>4</b>	<b>98.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан бүрэн ирүүлээгүй.	1	1					1	1				
Дүн	1	1					1	1				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл оруулаагүй.	1	490.8			1	490.8		
Дүн					1	490.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
								-
Нийт дүн	1	490.8			1	490.8		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР

Л.МӨНХ-ОРГИЛ



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 26/А2260439/ХӨА 2023/82  
НА-СТА-ТЦЗ

Мөрөн сум

### Хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй
2. Тайланд онд цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын 20 удаагийн нийт 320,315,300 (гурван зуун хорин сая гурван зуун арван таван мянга гурван зуун) төгрөг, зарлагын 6 удаагийн нийт 39,215,568 ( Гучин есөн сая хоёр зуун арван таван мянга таван зуун жаран найман) төгрөг, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг мэдээлэх талбарт 8 удаагийн нийт 72,400,000 (далан хоёр сая дөрвөн зуун мянган) төгрөг, 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 4 удаагийн нийт 58,006,100/ тавин найман сая зургаан мянга нэг зуун/ төгрөгийн, нийт 489,936,968 (дөрвөн зуун наян есөн мянга есөн зуун гучин зургаан мянга есөн зуун жаран найман) төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр өгөөжтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн

#### ШААРДАХ нь:

1. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан Ханх сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч Э.Бямбасүрэнд хариуцлага тооцох;
2. Дээрх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг таслан зогсоож, цаашид хууль, журмын холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах;

3. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Ханх сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Баасансүрэн нягтлан бодогч Э.Бямбасүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**


ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Л.МӨНХ-ОРГИЛ



<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043